

2019 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 21-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НОГООН ХӨГЖИЛ, АГААРЫН БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
ОРЛОГЧИЙН ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

2019 оны 02 дугаар сарын 01-ны өдөр

Улаанбаатар хот

№	Товч агуулга	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, биелэлт
1	Сар шинийн баярын өдрийг угтаж ахмад настанд хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Дүүргүүд, хэрэгжүүлэгч агентлагууд болон бусад харьяа газрууд/	Цагаан сар “Билгийн тооллын хаврын тэргүүн сар”-ын шинийн 1-ний өдрийг тохиолдуулан тус хотхонд амьдарч байгаа ганц бие өндөр настан, ахмад ажилчдад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулахаар газрын даргын А/07 дугаартай тушаалын дагуу 9 ахмадад тавгийн идээ, ааруул, сүү зэрэгийг нийт 768,000 төгрөгийг төсөвлөн хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсан. <b>Биелэлт-100%</b>
7	Инженерийн шугам сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангаж, ус, дулаан, цахилгаан хангамжаар байгууллага, иргэдийг тасалдуулахгүй, гэнэтийн гэмтэл, саатал гарахаас урьдчилан сэргийлэх. а. Шуурхай ажиллагааны бригад, жижүүрийн хуваарийг гарган, хяналт тавьж, болзошгүй осол, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх. /Захирагчийн ажлын алба, мэргэжлийн чиг үүргийн байгууллагууд, Дүүргийн Засаг дарга нар/	Тус газраас Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хороо 21 дүгээр хороололд шинээр ашиглалтанд орсон 63/1,63/2 дугаар байрны халаалтын болон хэрэглээний халуун усны төлбөрийн нэхэмжлэлтэй танилцаад 2018 оны 11 сарын 27-оос 2018 оны 12 сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд хэрэглэсэн халаалт, халуун усны төлбөр 2,844,668 /хоёр сая найман зуун дөчин дөрвөн мянга зургаан зуун жаран найман/ төгрөгийн төлбөрийг барагдуулах арга хэмжээг авч, оршин суугчдын хэрэглээний халуун усыг 2019.01.17-ны өдрөөс өгүүлсэн. Цагаан сарын амралтын өдрүүдэд буюу 2019.02.05-2019.02.11 өдрийг хүртэлх хугацаанд хариуцлагатай эргүүл жижүүр ажиллуулах хуваарийг урьдчилсан байдлаар гаргаж, ажилчдаас санал авч нэгдсэн хурал зохион байгуулан даргын тушаалын төсөл боловсруулж бэлтгэл ажлыг хангуулсан. <b>Биелэлт-100%</b>
8	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт, хог хаягдлуудыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж, хотын гудамж, талбайн гэрэлтүүлэгийн асалтад хяналт тавьж ажиллах. /Нийт байгууллагууд/	2019 оны 01 дүгээр сарын 27-ны хотхоны нийт ажилчдын өдөр 11 цагаас цуглуулж 813,814 901,902 дугаар байруудын нийтийн эзэмшлийн зам талбай дахь хуурай хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж цэвэрлэгээнд нийт 28 ажилтан бүрэн ороцож 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр СХД-ийн 21 хороо 63/1, 63/2 дугаар байрны гадна хуримтлагдсан хог хаягдлыг ачуулахад бэлэн болгож

№	Товч агуулга	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, биелэлт
		<p>нийтийн их цэвэрлэгээ хийлгэж үүсмэл хогийг арилгах арга хэмжээг авсан.</p> <p>2019 оны 01 сарын 28-ны өдөр хотхоны ерөө тасалгаанд их цэвэрлэгээ хийлгэж хотхоны эзэмшлийн байруудын гадна орчны цэвэрлэгээг хийлгэж хогийг хуваарийн дагуу Сүхбаатар дэвшил компаниар нийт 16 тонн хогийг 2019.01.30-ны өдөр ачуулах арга хэмжээ авсан.</p> <p><b>Биелэлт-100%</b></p>
10	<p>2019 онд Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчтай байгуулах Гүйцэтгэл, төлөвлөгөөний гэрээний бэлтгэл ажлыг хангах. /Гэрээний хавсралт төлөвлөгөөг улирал, сараар гаргаж, нийслэлийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2019 оны батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж НЗДТГ-ын хэлтсүүдээр хянуулж дуусгах/ /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нутгийн захиргааны байгууллагууд/</p>	<p>2019 онд Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчтай байгуулах Гүйцэтгэл, төлөвлөгөөний гэрээний бэлтгэл ажлыг хангаж, Гэрээний хавсралт төлөвлөгөөг улирал, сараар гаргаж, төсвийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, төслийг НӨХГ-т 2019.01.28-ны өдрийн 21 дугаартай албан бичигээр хүргүүлсэн. НЗДТГ-ын хэлтсүүдээр хянуулах хуудас авахаар ТЗУХ-ийн мэргэжилтэн н.Жавзмаагаас санал авах хуудас авахаар очиход түр хойшилсон гэж мэдэгдсэн.</p> <p><b>Биелэлт -90%</b></p>
11	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагууд болон албан хаагчид 02 дугаар сарын 05-ны дотор хөрөнгө орлогын мэдүүлгээ өгч дуусгах. /Нийт байгууллагууд/</p>	<p>Тус байгууллагын дарга 2019.02.01–ны өдөр хөрөнгө орлогын мэдүүлгээ цахимаар хүргүүлсэн.</p> <p><b>Биелэлт -100%</b></p>

ХЯНАСАН:  
ДУЛААНЫ ИНЖЕНЕР

Г.ЧУЛУУНБААТАР

БОЛОВСРУУЛСАН:  
ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

Г.БААТАРХҮҮ